дэмжих” нийтлэг зорилгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Олон нийтийн радио, телевизийн оролцооны олон улсын туршлага, хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлыг авч үзэхдээ мөнхийн хоёр хөрш улс ОХУ (хэвлэлийн эрх чөлөө хатуу хяналттай), БНХАУ (хэвлэлийн эрх чөлөө байхгүй), өрнөдийн хэвлэл мэдээлэлд өргөн тархсан либерал загвар бүхий АНУ (асуудалтай буюу хагас эрх чөлөөтэй), Их Британи (шаардлага хангасан буюу хангалттай эрх чөлөөтэй) болон манай улстай ижил төстэй хэвлэлийн хагас эрх чөлөөтэй Япон зэрэг улс орнуудыг тус бүрийн онцлогийг харгалзан сонгож судалгааны ажлаа хязгаарласан болно. Сонгосон улс орнуудын хэвлэл мэдээллийн орчны эрх зүйн зохицуулалт, технологийн шийдэл, санхүүжилтийн эх үүсвэр зэрэг нээлттэй мэдээллүүдийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, зарим баримт мэдээллийг Монгол Улстай харьцуулах зэрэг аргаар судлав.

Энэхүү судалгааны зорилго нь сонгож авсан улс орнуудын олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны онцлог, эрхзүйн зохицуулалт, технологийн шийдэл, онцгой байдлын үед дагаж мөрдөх удирдамж зэргийг олон талаас нь судлан тодорхойлж Монгол Улсын хувьд хэрэгжүүлэх боломжуудыг санал болгоход оршино.

Судлагдсан байдлын тухайд авч үзвэл Монгол Улсын хувьд сэтгүүлзүйн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачдын тухайн салбараар дагнасан бүтээл түгээмэл байх бол олон нийтийн мэдээллийн хэрэгслийг үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбон судлах асуудал орхигдож ирсэн байна. Харин доктор Б.Галаарид “Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил, төлөвшил¹⁸” нэг сэдэвт бүтээлдээ аюулгүй байдлын асуудлыг тусгай аспект болгон авч үзсэн, эрдэм шинжилгээний хоёр өгүүлэл нийтлүүлсэн байна. Мөн судлаач С.Буянхишиг¹⁹ “Нийгмийн аюулгүй байдлыг хангахад сэтгүүл зүйн бодлогын үзүүлэх нөлөө сэдэвт” нэг сэдэвт бүтээлдээ нийгмийн аюулгүй байдалд сэтгүүл зүйн бодлогын үзүүлж буй нөлөөний өнөөгийн байдалд шинжилгээ хийж, сөрөг нөлөөг бууруулах арга замыг тодорхойлсон байна. Сүүлийн үед олон улсын тавцанд анхаарал татаж, үндэсний аюулгүй байдалд нь сорилт тулгараад байгаа зарим улсуудын хэвлэл мэдээллийн орчинд өрнөсөн мэдээллийн өөрчлөлтийн талаар судлаачдын дүгнэлтэд, ОХУ нь Украйны тусгаар тогтнолын эсрэг мэдээллийн дайралтыг идэвхтэй явуулдаг гэж үздэг. Ингэхдээ Оросын төрийн мэдлийн RT, Sputnik зэрэг хэвлэлийн байгууллага, мөн Social Design Agency²⁰ гэх байгууллагаар дамжин уг ажиллагаа нь хийгддэг. Тэдний гол мэдээлэл нь Украйнд дотоод зөрчилдөөн бий болгох, барууны дэмжлэгийг сулруулах, Европын орнуудаас Оросыг дэмжсэн улс төрийн бодлогыг дэмжих зорилготой байдаг. Жишээ нь: Украйны дүрвэгсдийн талаар хуурамч мэдээ тарааж, эсвэл Украйны засгийн газрын баримт бичгийг хуурамчаар үйлдэн, ард иргэд, цэргийн албанд үүрэг гүйцэтгэж буй хүмүүсийг итгэл алдуулах зорилготой ажиллаж байсан тохиолдлууд байдаг²¹. Лив улсын тухайд хэвлэл мэдээллийн салбарт нөлөөлдөг орнууд бол Орос, Турк, Арабын Нэгдсэн Эмират гэж үздэг. Тухайлбал, ОХУ-тай холбоо бүхий Вагнер групп нь

¹⁸ Галаарид.Б., Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал //ХСУА. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. –УБ., 2016. т.33-38;

¹⁹ Буянхишиг.С. “Нийгмийн аюулгүй байдлыг хангахад сэтгүүл зүйн бодлогын үзүүлэх нөлөө” докторын зэрэг горилсон диссертаци. УБХИС. УБ 2024.171х

²⁰ <https://www.state.gov/russias-pillars-of-disinformation-and-propaganda-report/>

²¹ <https://www.rferl.org/a/russia-ukraine-disinformation-propaganda-campaign/33123498.html>

мэдээллийн дайралт явуулж, Ливийн иргэний дайнд нөлөөлөхийн тулд генерал Халифа Хафтарын талаар эерэг сурталчилгаа хийсэн байдаг. Эдгээр мэдээллийн кампанит ажлууд нь цэргийн болон эдийн засгийн дэмжлэгтэй хэрэгжиж, тус орны улс төрийн байдалд ихээхэн нөлөөлдөг гэж судлаачид үзэж байна²².

Бутан улс Украин болон Ливитэй харьцуулахад мэдээллийн дайралтад харьцангуй бага өртдөг. Гэвч тус улс хөрш орнуудынхаа, ялангуяа Энэтхэгийн хэвлэл мэдээллийн нөлөөнд²³ өртөх магадлал өндөртэй улс юм. Хэдийгээр Бутанд Украин болон Ливид тохиолдсон шиг ил тод мэдээллийн дайралт байхгүй ч, геополитикийн зөрчил нь тус улсын хэвлэл мэдээллийн орчинд шууд бус нөлөө үзүүлж байна гэж судлаачид үзсэн байдаг²⁴.

Гадаад улсуудын хувьд Үндэсний аюулгүй байдал ба хэвлэл мэдээллийн талаар судалгаа хийхдээ ихэвчлэн өөрийн орны болон гадаадын аль нэг улсын онцлогийг судалж, тухайн улс орон, бүс нутагтаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байна.

II. БҮЛЭГ 1. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН САЛБАР ӨНӨӨГИЙН БАЙДЛААР МОНГОЛ УЛС

Монголын хэвлэлийн хүрээлэнгээс гаргасан “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” тайланд дурдсанаар эзэмшлийн хувьд хувийн байгууллагын эзэмшилд 72 хувь, ТББ, холбоодод 17 хувь, Улс төрийн нам, эвслийн мэдэлд 4 хувь, Төрийн байгууллагын мэдэлд 6,5 хувь нь байна. Монгол Улсад 2020 оны эцэс гэхэд өдөр тутмын 8 сонин, 3-4 хоног тутмын дөрвөн сонин, 7 хоног тутмын 20, 10-14 хоног тутмын 29, сар тутмын 14 сонин хэвлэгдэн уншигчдад хүрч байна. Нийтдээ 10 сая 831 мянга 888 ширхэг сонин хэрэглэгчдэд хүрчээ. Сэтгүүлийн хувьд 7 хоног тутмын хоёр, 10-14 хоног тутмын хоёр, сар тутмын 24, хоёр сар тутмын зургаа, улирал тутмын 26, бусад буюу жилд 1-2 дугаар гардаг 9 сэтгүүл уншигчдэд хүрдэг байх нь.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд хамгийн өргөн цар хүрээг хамарч болох радиогийн хувьд тоон мэдээллүүдийг авч үзэж багцалвал үндэсний хэмжээнд нэвтрүүлэг цацдаг гурван радио, бүсийн хэмжээнд буюу Улаанбаатарт, аймгийн төвд болон хилийн чанадад долгионоо хүргэдэг долоо, зөвхөн Улаанбаатарын хэмжээнд цацдаг 24, тухайн орон нутагтаа нэвтрүүлэг нь хүрдэг 17 радио байна. Мөн радионуудын нэлээд нь интернэтээр цацагддаг болсон давуу талтай.

Монгол Улсад хамгийн олон хүнд мэдээлэл хүргэдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь телевиз хэвээр байсаар байна. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 20, Улаанбаатарын хэмжээнд эфирээ цацдаг 54, орон нутгийн 63 телевиз үйл ажиллагаа явуулж байна. Нийтдээ 137 телевиз нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж үзэгчдэд хүргэж байна.

Монгол Улсад “Олон нийтийн радио телевизийн тухай хууль”²⁵, “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль”²⁶ зэрэг эрх зүйн үндсэн зохицуулалтаар энэ салбарын

²² <https://www.state.gov/russias-pillars-of-disinformation-and-propaganda-report/>

²³ <https://www.state.gov/report-rt-and-sputniks-role-in-russias-disinformation-and-propaganda-ecosystem/>

²⁴ <https://www.rferl.org/a/russia-ukraine-disinformation-propaganda-campaign/33123498.html>

²⁵ Олон нийтийн радио телевизийн тухай хууль, УБ., 2005 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/

үйл ажиллагааг зохицуулдаг бөгөөд “Үндсэн хууль”²⁷, “Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал”²⁸ гэх мэт суурь гэж хэлж болох эрх зүйн бичиг баримтуудад үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтууд мөн үйлчилж байна.

ХӨРШ ОРНУУДЫН ОНЦЛОГ

ОХУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх зүйн зохицуулалт. ОХУ-ын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцааг Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, нэгдэн орсон гэрээ, хэлэлцээр, Үндсэн хууль, Мэдээллийн аюулгүй байдлын номлол, “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай” Холбооны хууль, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг.

Бусад хууль тогтоомжид “Мэдээлэл, мэдээллийн технологи, хамгаалалтын тухай” Холбооны хууль (2006.06.27), “Зар сурталчилгааны тухай” Холбооны хууль (2006.03.13), Төрийн болон Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах боломжийг хангах тухай” Холбооны хууль (2009.02.09), гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг үгүйсгэсэн мэдээллээс хүүхдийг хамгаалах зорилготой “Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд хор хөнөөл учруулах мэдээллээс хамгаалах тухай” Холбооны хууль (2012.07.28) багтаж байна.

ОХУ нь 2000 онд “Мэдээллийн аюулгүй байдлын номлол”-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус номлол нь ОХУ-ын мэдээллийн салбар дахь төрийн бодлогын зохицуулалтын тогтолцооны үндэс болохын хувьд мэдээллийн аюулгүй байдлын зорилго, зарчим, үндсэн чиглэлийг тодорхойлсон холбооны түвшний баримт бичиг юм.

“Хэвлэл мэдээллийн тухай хууль”-д хэвлэл мэдээллийнхэн олгосон эрх чөлөөг хэтрүүлэн ашиглаж болохгүй гэж заасан байдаг. Түүнчлэн онц байдал, дайны байдал үүссэн тохиолдолд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлахыг хуулиар зөвшөөрдөг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ийм тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах нь "Онц байдлын тухай" Холбооны Үндсэн хууль, "Дайны байдлын тухай" Холбооны Үндсэн хуулиар тодорхойлогддог.

Хүний нэр төр, алдар хүндийг гутаасан худал мэдээллийг санаатайгаар тараасан тохиолдолд нэг сая хүртэлх рубль болон нэг жилийн цалин, орлого, эсвэл 240 цаг хүртэлх хугацааны албадан хөдөлмөр эрхлүүлэх, зохиогчийн эрхэд ноцтой хохирол учруулсан плагиатын тохиолдолд 200 мянган рублиэс 18 сарын цалин, орлого эсвэл 480 цаг хүртэлх хугацааны албадан хөдөлмөр эрхлүүлэх, салан тусгаарлах, хэт даврах үзэл, терроризмд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан уриалан дуудсан тохиолдолд ажил эрхлэх эрхийг хасаж, 5 жилийн хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлэх, эсвэл 5 жилийн хугацаагаар хорих гэх мэт олон заалтаар хариуцлага оногдуулдаг байна.

²⁶ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, УБ., 2019 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/ Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992

²⁷ Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992

²⁸ Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал, УБ., 2010 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/

БНХАУ-ын хэвлэл мэдээллийн салбар ба нийгмийн аюулгүй байдлын нөлөөлөл. Тус улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянан цагдах ажил 1980-аад оны үед буюу төрийн эрхэнд Дэн Сяопин гарч ирсэн үед харьцангуй чөлөөтэй болсон байна. Гэвч 1989 оны 6 дугаар сарын 4-ний үйл явдал буюу “Тяньаньмэний хядлага”-ын үйл явдалд “Ардын өдрийн мэдээ” зэрэг сонинууд татагдан орсноос хойш хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын мэдээний сонинд тавих хяналт дахин чангарсан.

1990-ээд оны сүүл үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл дахин өчүүхэн ч атугай эрх чөлөө амссан боловч интернэтийн хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр Хятадын төрийн бодлогыг шүүмжилсэн, бослого самуунд уриалсан мэдээллүүд их хөврөх болсон учир Ху Жинтаогийн Засгийн газар хатуу хяналт тогтоох хууль²⁹ баталсан байдаг. Ийнхүү тус хуулиар бол БНХАУ-ын Засгийн газар нь ОНМХ-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох болсон ба Хятадын хэвлэл мэдээллийн тэргүүлэгч байгууллага (“ССТV”, “Ардын өдрийн мэдээ”, “Синьхуа” агентлаг)-ыг төрийн мэдэлд авсан байна. БНХАУ-ын Засгийн газраас баталсан хуульд “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын мэргэжлийн ёс зүй, нийгмийн өмнө хүлээсэн нэн тэргүүний үүрэг нь тэд өөрийн үүргээ бүрэн ухамсарласан ажилтан байж төр засгийн бодлогыг олон нийтэд түгээх дуу хоолой нь байх ёстой” гэнэ.

ОНМХ-ийн зүгээс төр засгийн мэдээ, мэдээллийг дэлгэх, олон нийтэд хүргэх ажлыг “Төрийн мэдээллийг олон нийтэд хүргэх тухай” хуулиар зохицуулдаг байна. Тус хуульд ОНМХ болон хувь хүн төрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хэрхэн авах тухай хуульчлан зааж өгсөн байдаг буюу “...олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага болон хувь хүн төрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлтэй танилцах эрхтэй...” ч холбогдох мэдээллийг авах тухай зөвшөөрлийг хэрхэн авах нөхцөл заасан байдаг буюу зөвшөөрөл хүсэж буй мэдээлэл нь эрдэм шинжилгээний ажил, аж ахуй эрхлэхтэй холбоотой эсэх гэх мэт нэн чухал шалтгаантай бол зөвшөөрөл хүсэх эрх нь нээгддэг байна.

БНХАУ-ын ОНМХ нь гагцхүү Засгийн газрын зөвшөөрөлтэйгөөр мэдээллийг олон нийтэд түгээн сонордуулах үүрэгтэйгээр төрийн мэдээллийг дэлгэх эрхтэй буюу төр ард түмэн хоёрын холбогч, зуучлагч нь байж Засгийн газраас олгосон бичвэрийг эхээр нь дамжуулах, түгээх хэрэгсэл нь болдог байна.

Үүнээс гадна БНХАУ-ын “Төрийн мэдээллийг дэлгэх тухай” хуультай салшгүй хамт явдаг нэгэн хууль бол “Төрийн нууцыг хамгаалах” тухай хууль болно. Тус хуулиар БНХАУ-ын иргэд нь төрийн нууцыг чандлан хамгаалах үүрэгтэй.

²⁹ О защите государственной тайны: Закон КНР (принят на 3-й сессии Постоянного комитета ВСНП КНР седьмого созыва 05.09.1988 г., обнародован Указом Председателя КНР от 05.09.1988 г. № 28, изменения и дополнения приняты на 14-й сессии Постоянного комитета ВСНП КНР одиннадцатого созыва 29.04.2010 г.) / пер. А.Ю. Манцурова. 中华人民共和国保守国家秘密法 (1988 年 9 月 5 日第七届全国人民代表大会常务委员会第三次会议通过, 中华人民共和国主席令第二十八号, 2010 年 4 月 29 日第十一届全国人民代表大会常务委员会第十四次会议修订) URL: <http://www.mps.gov.cn>.

БНХАУ-ын Засгийн газар ОНМХ-д нийтлэгдэж буй мэдээллийг улс төрийн шалтгаанаар дараах асуудлуудыг хөндсөн нийтлэлд хориг тавьдаг байна. Үүнд: улс төрийн сөрөг хүчний талаар асуудал дэвшүүлэх, ХКН-ын нэр хүндэд муугаар нөлөөлөхүйц, нэр хүндэд нь сэв суулгаж болзошгүй гэж үзсэн мэдээ, нийтлэл буюу тухайлбал, 1989 онд Тяньаньмэний талбайд болсон цуст аллага, Хятадын ардчиллын төлөөх хөдөлгөөн, Шиньжааны уйгурчуудын хэл, соёлынхоо төлөөх тэмцлийг нухчин дарж, хоморголон устгаж буй тухай, Тайванийн тусгаар тогтнолын хөдөлгөөн, фалуныгун эсвэл Хонгконг дахь ардчиллыг дэмжсэн жагсаал, хөдөлгөөн, Далай лам, Түвдийн асуудал, мөн Бүгд найрамдах улсын үеийн Гоминданы намын зүгээс өөрийн хяналтаа тогтоохын тулд ард түмний эсрэг чиглэсэн 2 дугаар сарын 28-ны үйл явдалд зориулсан гэх мэт сэдвүүд багтдаг.

Эдгээр хуулиудаас үзвэл БНХАУ-д аливаа мэдээлэл, ялангуяа төр, засгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл олон нийтэд хүргэх нь хатуу хяналт дор байдаг ба ОНМХ-ээс бэлтгэн олон нийтэд хүргэж буй мэдээ нь Засгийн газраас нийтлэхийг хориглосон буюу тус улсын төр, засгийн үйл ажиллагааг муулсан, үндэстэн, угсаатны бүлгүүдийн хагалан бутаргах, хориотой сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх, дэвэргэх, өдөөн турхирах, шашны гэх мэт өнгө аяс агуулаагүй байх ёстой. 2012 онд Ши Жиньпин ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болсноос хойш олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих хяналт улам хатуу болсон гэж үздэг. ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ши Жиньпин нь 2013 онд интернэтийн хяналт шалгалтын хэлтсийг “бүх Хятадын цахим ертөнцийн удирдлага, суртал ухуулгын агентлаг” буюу сүлжээний зохицуулалт эрхлэн гүйцэтгэдэг хараат бус, бие даасан агентлаг болгон шинэчлэн зохион байгуулсан. Тус агентлагийн зорилго нь намын засаглалын тогтвортой байдал, статус-квог хадгалах явдал ба улс төрийн хяналт гэдэгт юуны өмнө олон нийтийн ёс суртахуунд муугаар нөлөөлөхүйц, хортой нийтлэлүүдийг хянан шүүх, устгах, улс төрийн сэдэвтэй мэдээ, мэдээлэлд хяналт тавих зэрэг багтдаг.

Цахим мэдээллийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд 60 хоногийн туршид өөрийн нийтэлсэн мэдээ, мэдээллийг хадгалах үүрэгтэй ба эрх бүхий байгууллага, цагдаагийн ажилтанд саадгүй үзүүлэх үүрэгтэй. Төрийн зөвлөлийн 2024 оны 8-р сарын 30-ны өдрийн 40-р Гүйцэтгэх хурлаар батлагдсан Сүлжээний мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын журмыг³⁰ нийтэлсэн хувь хүний нууцыг хэрхэн хамгаалах, улсын нууцад хамаарах мэдээллийг хэрхэн хамгаалах, хил дамнасан мэдээллийн урсгалыг хэрхэн хянан зохицуулах, интернэт платформ зохицуулагчдын эрх үүрэг, хянан шалгах хийгээд хуулийн хүрээнд эдлэх эрх зэргийг тусгасан байдаг. Шуурхай мэдээг³¹ ХКН, Засгийн газар, Цэргийн Төв Зөвлөлөөс эрхлэн хүргэнэ. Үүнд, эрх бүхий тэргүүлэх хэлтсүүд дээд шатны байгууллагуудад захирагддаг алба, хэлтсүүдийн ажлыг удирдан чиглүүлэхэд зориулсан иж бүрэн мэдээ, тайлан бүхий эмхэтгэлээр хангадаг. Эдгээр дотоодын

³⁰ https://www.gov.cn/zhengce/zhengceku/202409/content_6977767.htm

³¹ О национальной безопасности: Закон КНР (принят на 15-й сессии Постоянного комитета ВСНП КНР двенадцатого созыва 01.07.2015 г., обнародован Указом Председателя КНР от 01.07.2015 г. № 29) / пер. А.Ю. Манцурова. 中华人民共和国国家安全法 (2015年7月1日第十二届全国人民代表大会常务委员会第十五次会议通过中华人民共和国主席令第二十九号公布) URL: <http://www.mps.gov.cn>.

буюу хязгаарлагдмал хүрээнд мэдээлэл бэлтгэн хүргэдэг байгууллага, нэгжүүдийн хамгийн гол үүрэг нь “Нөхцөл байдлын мэдээ, тайлан” хэмээх сар бүр бэлтгэн хүргэдэг нөхцөл байдлын үнэлгээ ажээ. Энэхүү нөхцөл байдлын тайланд Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр батлагдсан хууль, дүрэм зөрчсөн тохиолдлууд, тухайн тохиолдол бүрт оногдуулсан торгуулийг жагсаасан байдаг ажээ.

Ийнхүү Хятадын төрөөс интернэт буюу Хятадын социал ертөнцийг “уяаг нь сулруулах” зарчмаар хянахын зэрэгцээ өмнө тэмдэглэсэнээр улс төрийн суртал ухуулгын нэгэн чухал хэрэгсэл гэж харж байна.


III. БҮЛЭГ 2. ЗАРИМ УЛС ОРНУУДЫН БАРИМТАЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АНХААРАЛ ТАТСАН ЖИШГҮҮД

АНУ-ын хэвлэл мэдээллийн орчин. АНУ-д хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах нь ардчиллын чухал зарчим болж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, иргэний таньж мэдэх болон үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулан хангахад онцгой анхаардаг.

АНУ бол интернэтийн эх орон бөгөөд YouTube, Facebook, Instagram нь тэргүүлэх платформуудтай. Телевиз бол АНУ-д хамгийн өргөн түгсэн мэдээллийн хэрэгсэл юм. Кабель, хиймэл дагуул телевизийн салбарт нэвтэрч “Fox” сүлжээг бий болгох хүртэл “ABC”, “CBS”, “NBC” Америкийн телевизийн зах зээлд тэргүүлдэг байсан. “Fox News” суваг бол АНУ-ын кабелийн мэдээний тэргүүлэгч компани юм.

Түүнчлэн, АНУ-ын Засгийн газрын санхүүжилтгүйгээр бусад орон, тэр дундаа хуучин ЗХУ, Ойрхи Дорнод, Ази, Куба зэрэг бүс нутаг, улс орнуудад тусгайлан зориулсан хөтөлбөрүүдийг хүргэдэг.

Пью судалгааны төвийн 2021 оны 7 дугаар сарын 26-аас 8 дугаар сарын 8-нд явуулсан судалгаагаар АНУ-ын насанд хүрсэн иргэдийн тал шахуу хувь (48%) нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээс “байнга” эсвэл “хааяа” мэдээлэл авч байсан нь 2020 онтой харьцуулахад 5 хувиар буурсан үзүүлж болж байна¹⁵.



2.1 дүгээр зураг. Нийгмийн сүлжээнээс мэдээлэл авдаг АНУ-ын насанд хүрсэн иргэдийн хувь (2020-2021 он)

¹⁵ <https://www.pewresearch.org/journalism/2021/09/20/news-consumption-across-social-media-in-2021/>

Америкчууд нийгмийн сүлжээний аль хэрэгслээс илүүтэй мэдээлэл авдгийг асуухад фейсбүүк бусад платформоос түлхүү дурдагдсан байна. Нийгмийн сүлжээний түгээмэл хэрэглэгддэг 10 цахим хуудасны алинаас нь мэдээлэл авдаг болохыг нь асуухад, АНУ-ын насанд хүрэгчдийн 1/3 орчим нь (31%) фейсбүүкээс тогтмол мэдээлэл авдаг хэмээн хариулсан бол 5 америк тутмын нэг нь (22%) юүтүүбээс тогтмол мэдээлэл авч байна. Твиттер (13%) болон инстаграм (11%) нь америкчуудын мэдээллийн байнгын эх сурвалж болоод байна¹⁵¹⁶.

АНУ-ын хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалтын хувьд төрөөс нийт ард иргэдийнхээ аюулгүй байдлыг хангахад нь харшлах төрийн нууцын зэрэглэлтэй материалыг нийтлэх нь хуулиар хориотой. Тус улсын шүүхийн тогтолцооны хүрээнд хэвлэмэл мэдээ бэлтгэдэг мэдээллийн хэрэгслүүдэд хяналт тавьдаг бол шүүх байгууллагууд болон Холбооны харилцаа холбооны хороо (Federal Communications Commission) хэмээх Засгийн газрын зохицуулах байгууллага нь радио, телевизийн нэвтрүүлэг, контентод хяналт тавьдаг.

Холбооны харилцаа холбооны хорооноос дараах хэд хэдэн чухал зарчмыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг. Үүнд:

- "Тэгш цаг олгох дүрэм"-ийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгчид улс тодорхой албан тушаалд нэр дэвшигчдэд зориулан адил хугацааны нэвтрүүлгийн цаг олгох үүрэгтэй. Олон жилийн хугацаанд энэхүү зохицуулалтад өөрчлөлт орсон.

- "Няцаах эрхийг хангах журам"-ын дагуу өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгчид шүүмжлэлд хариу өгөх боломжийг улс төрийн нэр дэвшигчдэд олгох үүрэгтэй. Өргөн нэвтрүүлгийн аль нэг суваг нэр дэвшигч рүү дайралт хийх тохиолдолд шүүмжлэлд хариу өгөх боломжийг тухайн нэр дэвшигчид олгох шаардлагатай.

- "Шударга ёсны зарчим"-ын дагуу, маргаантай асуудлаар нэвтрүүлэг цацагдах тохиолдолд эсрэг үзэл бодолтой хүмүүст адилхан цаг гаргаж өгөхийг өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэгчдээс шаарддаг байна.

- "Зохисгүй агуулгыг зохицуулах журам" нь насанд хүрээгүй хүүхдүүд бүдүүлэг зохисгүй үг хэллэг, садар самуун дүрслэлтэй агуулгыг үзэж, сонсох нөхцөлийг хязгаарлаж, тодорхой цагуудад (оройн 22 цагаас өглөөний 6 цаг хүртэл) нэвтрүүлэх зохицуулалт хийхэд чиглэдэг. АНУ-ын Дээд шүүх ийм агуулгыг зохицуулах эрх мэдлийг баталгаажуулж, Холбооны харилцаа холбооны хорооноос зөрчил гаргагчдад их хэмжээний торгууль ноогдуулдаг.

Япон улсын олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны онцлог. Тус улсын "Өргөн нэвтрүүлгийн хууль" нь 1950 онд батлагдсанаас хойш 20-иод удаа засварлагдан шинэчлэгджээ. Энэ хуулиар анх Японы өргөн нэвтрүүлгийн корпорац (NHK) байгуулагдаж, өнөөдөр хувь нийлүүлсэн олон нийтийн корпорацийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн NHK-гээс бусад хувийн компаниудад өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн нь мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангахад чухал ач холбогдолтой болсон байна.

Япон улс газар зүйн онцгой байрлалд оршдоогоос шалтгаалж далайн хар шуурга, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт их өртдөг, түүнийг даван туулахын тулд ихээхэн арга хэмжээ зохион байгуулдаг улс юм.

Байгалийн гамшгийн үед ОНРТ-ийн нийгэмд гүйцэтгэх үүрэг асар их бөгөөд нэгдүгээрт, цаг агаарын урьдчилсан мэдээ, гамшгийн хохирлын мэдээ, нүүлгэн шилжүүлэлтийн мэдээ зэрэг үнэн зөв, найдвартай мэдээллээр богино хугацаанд ард иргэдийг хангаж, учирч болох эрсдэлээс хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах, хоёрдугаарт гамшгийн үеийн бэлэн байдалд үргэлж анхаарч, урьдчилан тооцоолон техникийн бүрэн бүтэн байдал, нөөцөд анхаарч мэдээллийг түгээх үйл ажиллагааг тасралтгүй хангах үүрэг хүлээдэг байна.

Япон Улсын Дотоод хэрэг, харилцаа холбооны яамнаас ард иргэдийн дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд “66 хувь нь гамшгийн үеийн мэдээллийг авахад хамгийн их хэрэглэдэг мэдээллийн хэрэгсэл нь телевиз, радиогийн өргөн нэвтрүүлэг”¹⁷ хэмээн нэрлэжээ. Энэ мэтчилэн гамшгийн үед энгийн үеийнхээс илүү өргөн нэвтрүүлгээр найдвартай, үнэн зөв мэдээлэл дамжуулах шаардлага, үүргийг нийгмийн өмнө хүлээсэн байдаг гэж хэлж болно.

Гамшгийн үед тухайн нөхцөл байдлаас шалтгаалан радио, кабелийн телевиз, интернэт өргөн нэвтрүүлэг нь өөр өөрийн давуу болон сул талтай бөгөөд аль аль нь бэлэн байдалд байх ёстойг үйл ажиллагаа явуулагч хуулийн этгээдүүд “Өргөн нэвтрүүлгийн хууль”-аар хүлээсэн байдаг.

Өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нь “Өргөн нэвтрүүлгийн хууль”-ийн дагуу нэвтрүүлгийн байгууламжид гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй. Өргөн нэвтрүүлгийн төрөл бүрийг Дотоод хэрэг, харилцаа холбооны яамны Сайдын тушаал “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг сахиулах журам”-д заасан техникийн стандартад нийцүүлэн зохион байгуулах ёстой бөгөөд нөөц төхөөрөмжийг суурилуулах, эвдрэлийг илрүүлэх, газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээ, цахилгаан тасрах үед авах арга хэмжээ, салхи, үерийн хохирлын эсрэг арга хэмжээ зэрэг арга хэмжээ авахаар заасан байдаг.

Хэдийгээр өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг эрхэлдэг хуулийн этгээдүүд хувийн өмчийн хэлбэртэй боловч бүх нийтийг хамарсан гамшгийн үед Япон улсын Дотоод хэрэг, харилцаа холбооны сайдын нэгдсэн удирдлагад байж, онцгой нөхцөл байдалд хуулиар хүлээсэн үүргээ хэлбэрэлтгүй даган мөрдөх үүрэг хүлээдэг.

Их Британийн хэвлэл мэдээллийн орчин. Их Британи улс дэлхийн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өнөөгийн хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр оруулсан гэж хэлж болно. 1800-аад оны эхэн үед Их Британид The Times of London зэрэг сонин хэвлэгдэж, олон уншигчдын хүртээл болж, нийтэд танигдаж чадсан байна.

Британийн үндэсний British Broadcasting Corporation буюу BBC-ийн түүх бүр 1922 оноос эхлэлтэй бөгөөд анхны радио нэвтрүүлгээ 1920 онд цацаж, телевизийн

¹⁷ “Өргөн нэвтрүүлгийн эргэн тойрон дахь асуудлуудад холбогдох судалгааг хэлэлцэх нь”. Гамшгийн үед өргөн нэвтрүүлгийн аюулгүй байдлыг хангах эрдэм шинжилгээний хурлын тайлан. 放送を巡る諸課題に関する検討会 災害時の放送の確保に関する検討分科会 報告書』 https://www.soumu.go.jp/main_content/000700865.pdf

туршилтын нэвтрүүлгийг 1929 онд, тогтмол нэвтрүүлгүүдийг 1936 оноос явуулж эхэлсэн байна. Эндээс үзэхэд дэлхийн хэвлэл мэдээллийн түүх Их Британийн түүхэн он цагтай давхцаж байгаа бөгөөд, хэвлэл мэдээллийн салбарын баялаг их түүх уламжлалаараа Их Британи онцлогтой юм.

Өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг зохицуулж, хяналт тавьдаг гол байгууллага бол Ofcom (Office of Communications) юм. Тус байгууллага 2003 онд батлагдсан Харилцаа холбооны тогтоолоор (Communications Act 2003) үйл ажиллагааны бүрэн эрхээ олж авсан. Харин өдгөө Ofcom өмнө хэрэглэгдэж байсан кодуудаас оролцуулан, нэмж завсарласан 10 хэсэгтэй

Өргөн нэвтрүүлгийн кодыг (Broadcasting Code) батлан, дагаж мөрддөг. Тухайн кодын дагуу жишээ нь хүүхдэд тохиромжгүй мэдээ мэдээлэл, контентыг 17:30-21:00 цагийн хооронд гаргахгүй байхыг шаардана. 2010 онд энэхүү кодыг зөрчиж, өдрийн цагаар насанд хүрэгчдэд зориулсан агуулгатай мэдээлэл цацсан 4 телевизийн сувгийн зөвшөөрлийг цуцалжээ. Эдгээр кодыг сийрүүлбэл:

1-р хэсэг: 18-с доош насныхны аюулгүй байдал

2-р хэсэг: Сөрөг мэдээлэл, аюул заналхийлэл /энэ хэсэгт дайрч доромжилсон, заналхийлсэн сөрөг мэдээ контентоос ард иргэдийг хамгаалахын тулд өргөн нэвтрүүлгийн мэдээнд тавигдах стандартыг тодорхойлно/

3-р хэсэг: Гэмт хэрэг, үймээн самуун, үзэн ядалт, хүчирхийлэл /энэ хэсэгт Ofcom хүлээсэн үүргийнхээ дагуу иймэрхүү мэдээллийг гаргахыг хориглохтой холбоотой кодууд хамаарна/

4-р хэсэг: Шашин /энэ хэсэгт нэвтрүүлэгч байгууллагууд шашны холбогдолтой хөтөлбөрүүдэд хүндэтгэлтэй хандах тухай кодууд багтана/

5-р хэсэг: Төвийг сахих болон ил тод байдал /энэ хэсэгт мэдээ ямар ч нөхцөл байдалд байсан мэдээлэгч үнэн бодитоор, ил тод байдлыг хангаж, хэт нэг талыг баримтлахгүйгээр мэдээлэхтэй холбоотой кодууд байна/

6-р хэсэг: Сонгууль болон бүх нийтийн санал асуулга /энэ хэсэгт сонгуулийн үеэр мөн аль нэг талыг баримтлахгүй байх кодууд байна/

7-р хэсэг: Шударга ёс /энэ хэсэгт нэвтрүүлэгч байгууллага аливаа хувь хүн, хуулийн этгээдэд шударга бус хандахаас хамгаалсан кодууд байна/

8-р хэсэг: Хувийн нууцлал /энэ хэсэгт нэвтрүүлэгч байгууллага мэдээлэл олж авах зорилгоор хувийн нууц задруулах, үндэслэлгүйгээр хувийн нууцад халдахаас зайлсхийхтэй холбоотой дүрмүүд байна/

9-р хэсэг: Телевизийн зар сурталчилгаа

10-р хэсэг: Радиогийн сурталчилгаа

2019 онд Их Британийн Засгийн газар “Цахим орчны аюул заналхийллийн тухай илтгэл”-дээ цахим мэдээ мэдээлэл, контент хувь хүнд, ялангуяа бага насны хүүхдэд ямар их аюул учруулж байгаа тухай, энэ асуудал дээр ямар нэг шийдвэртэй арга хэмжээ авалгүй их удсан тухайгаа тэмдэглэсэн байна. Энэ байдлаас гарахад яаралтай хуулийн зохицуулалт хийж, интернэт компаниудад зориулсан кодыг хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байгааг онцолсон байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газар Ofcom-ыг мөн Цахим орчин дах зохицуулалт хийх байгууллага болгох саналтай байгаагаа 2019 онд мэдэгдсэн.

Онцгой байдлын үед Их Британийн Үндэсний өргөн нэвтрүүлгийн гол байгууллага болох BBC улс орон даяар мэдээллийг түгээх албан ёсны үүрэгтэй байдаг. Онцгой байдлын үед дагаж мөрдөх удирдамж 11-р хэсэгт Дайн, террорист үйл ажиллагаа, онцгой байдал (War, Terror, Emergencies) гэсэн нэрээр тусгагджээ. Уг хэсэгт үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдлыг нэг бүрчлэн оруулж, тухайн нөхцөл бүрд ямар арга хэмжээ авах, хэрхэн нэвтрүүлэг бэлтгэх талаар дэлгэрэнгүй тайлбарласан байна. Дэд хэсгүүдийг дараах байдлаар тусгаж өгсөн байна:

- *Алдаагүй, алагчлалгүй байх (Accuracy and Impartiality)* - Үндэсний болон олон улсын хэмжээний онцгой байдлын талаар мэдээлж байгаа бол /дайн, терроризмын үйл ажиллагаа, байгалийн гамшиг.../ гуравдагч талаас ирсэн мэдээлэлд эх сурвалжийг заавал дурдах, хохирогчийн зүгээс өгсөн тооцоо мэдээ ихэвчлэн нарийн, тодорхой байдаггүй учир илүү эрх мэдэлтэй, үндэслэлтэй мэдээлэл өгсөн эх сурвалжийн мэдээг баримтална. Жагсаал цуглаан, үймээн самууны мэдээг хүргэхдээ үүнд оролцогч, хамрагдагч талуудын тухай үл итгэсэн, эргэлзсэн байр сууринаас мэдээлэл бэлтгэвэл зохино.

- *Хэл ярианы сонголт, хэрэглээ (Use of Language)* - Терроризм бол улс төрийн чухал агуулга бүхий хүнд хэцүү, сэтгэл хөдөлгөсөн сэдэв учир энэ хүрээнд ашиглах үг хэллэгийг сонгохдоо болгоомжтой байх шаардлагатай. "Террорист" гэдэг нэр томъёог ямар нэг эх сурвалжгүйгээр ашиглаж болохгүй.

- *Хохирогчдыг тодорхойлох (Identifying Victims)* - Хүмүүс амь насаа алдсан, шархадсан, сураггүй алга болсон тохиолдолд ойр дотынхон нь BBC-ийн сувгаас олж мэдэх ёсгүй, харин холбогдох байгууллагууд тэдэнд мэдэгдэх ёстой. Харин бид хохирогч нэг бүрийг тодорхойлж хугацаа алдахгүйгээр, олон нийтийн сэтгэл зовнилыг багасгахын тулд гол гол чухал мэдээллүүдийг (жишээ нь онгоцны сүйрэл гарсан тохиолдолд нислэгийн компанийн тухай мэдээлэл, нислэгийн дугаар, хаанаас хаана хүрч байсан чиглэлийн тухай мэдээлэл зэрэг) аль болох хурдан хугацаанд өгөх нь чухал.

- *Эмх замбараагүй байдал, үймээн самуун (Disturbances and Riots)* - Эмх замбараагүй байдал, үймээн самууныг өргөн цар хүрээнд хамруулж, мэдээ бэлтгэх нь бидний хувьд их чухал боловч Алдаагүй, Алагчлалгүй байх удирдамжийнхаа хүрээнд анхаарах чухал зүйл бол бид үймээн самууны тухай мэдээ дамжуулснаар үймээн самууныг улам өдөөж байгаа эсэх, хэрэв тийм бол аль болох хурдан мэдээгээ зогсоох,

- *Урьдчилан бэлдсэн арга хэмжээ (Staged Events)* - Их Британийн ард иргэдийн эсрэг айлган сүрдүүлсэн агуулгатай урьдчилан бэлдсэн мэдээг дамжуулах санал ирвэл Редакцын даргын бодлого, стандартын дагуу шийдвэрлэнэ.

- *Аюул заналхийлэл ба хууран мэхлэлт (Threats and Hoaxes)* - Хэрвээ бидэнд тэсрэх бөмбөг болон бусад аюулт зэвсгийн талаар анхааруулга ирвэл хамгийн түрүүнд холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Бид халдлагыг өдөөж болох аюулгүй байдлын дэлгэрэнгүй мэдээлэл эсвэл олон нийтэд нээлттэй бус бусад нууц мэдээллийг задруулах ёсгүй.

- *Хүн хулгайлах, барьцаалах, бүслэлтэд авах (Hijacking, Kidnapping, Hostage-Taking and Sieges)* - Хүн хулгайлах, барьцаалах, бүслэлтэд авах зэрэг нөхцөл

байдлын талаар мэдээлэхдээ үргэлж Их Британид байгаа болон гадаад улсад байгаа гэмт хэрэгтнүүд шууд болон шууд бусаар мөн сонсож, тухайн мэдээллийг авч байгааг санах хэрэгтэй.

- *Үндэсний аюулгүй байдал ба терроризмын эсрэг (National Security and Counter-Terrorism)* - Бидний Үндэсний аюулгүй байдал болон тагнуулын асуудлын талаар мэдээлэх эрх Албаны нууцын актаар (The Official Secrets Act) хязгаарлагдана.

- *Терроризмын Акт (Terrorism Acts)* - Терроризмын актаар хүлээсэн үүргийнхээ дагуу бид хэрэв дэлхийн хаана ч терроризмын үйл ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлэхэд нөлөөлөх боломжтой мэдээ материал бидэнд байна гэж үзвэл тухайн нууцаа цагдаагийн байгууллагад задруулах үүрэгтэй.

- *Дайсагнасан орчин ба аялах зөвлөмж (Hostile Environments and Travel Advisories)* - Хэрэв Дайсагнасан уур амьсгалтай, аялах зөвлөмжийг дагаж мөрддөг улс юм уу бүс нутагт зорчих болсон тохиолдолд заавал ВВС-ийн Аюулгүй байдлын өндөр эрсд лийн багт хандах ёстой.

IV. Дүгнэлт

Олон нийтийн радио, телевизийн оролцооны гадаадын зарим орны туршлага, хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлыг авч үзэхдээ мөнхийн хоёр хөрш улс ОХУ (хэвлэлийн эрх чөлөө хатуу хяналттай), БНХАУ (хэвлэлийн эрх чөлөө байхгүй), өрнөдийн хэвлэл мэдээлэлд өргөн тархсан либерал загвар бүхий АНУ (асуудалтай буюу хагас эрх чөлөөтэй), Их Британи (шаардлага хангасан буюу хангалттай эрх чөлөөтэй) болон манай улстай ижил төстэй хэвлэлийн хагас эрх чөлөөтэй Япон зэрэг улс орнуудыг авч судаллаа.

Сонгосон улс орнуудын хэвлэл мэдээллийн орчны эрх зүйн зохицуулалт, технологийн шийдэл, санхүүжилтийн эх үүсвэр зэрэг нээлттэй мэдээллүүдийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, зарим баримт мэдээллийг Монгол Улстай харьцуулах зэрэг аргаар судалж Монгол Улсын хувьд олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны онцлог, эрхзүйн зохицуулалт, технологийн шийдэл, онцгой байдлын үед дагаж мөрдөх удирдамж зэргээс өөрийн улс орондоо хэрэгжүүлэх боломжуудыг санал болгож байна?

Дээрх улс орнуудын аюулгүй байдлаа хамгаалахдаа авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, баримталж буй бодлогоос манай улс өөртөө нутагшуулан авч, хэрэгжүүлж болох хэд хэдэн санаа байна.

Үүнд:

1. *Мэргэжил арга зүйн хувьд* нийтэд хүрч байгаа бүх хэлбэрийн мэдээ, контентын хэм хэмжээг тогтоож өгдөг Код гэх ойлголт юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүх сувгийн мэдээ бүгд кодоор дамжиж, кодоод заагдсан хэм хэмжээнд тохируулагдан иргэд, олон нийтэд хүрдэг байна. Их Британид хэвлэл мэдээллийн хэрэгслийн баялаг туршлагаас суралцах зүйл бидний хувьд их бөгөөд ялангуяа онцгой нөхцөл байдлыг нэг бүрчлэн оруулж, тухайн нөхцөл бүрд ямар арга хэмжээ авах, хэрхэн нэвтрүүлэг бэлтгэх талаар дэлгэрэнгүй тайлбарласан нь анхаарал татав;

2. *Илт тод нээлттэй байдлын хувьд* Ард иргэдээс ирэх санал гомдлыг нээлттэйгээр хүлээн авдаг нь цацагдсан мэдээ, мэдээллийн чанарын үнэлгээ болох

бөгөөд хэрэглэгч, мэдээллийн байгууллага хоорондын эргэх холбоог бат бөх, ил тод байлгах давуу талтай;

3. *Эрх зүйн зохицуулалт, хараат бус байдлын хувьд* Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөрөнгө оруулагч, улс төрийн хамаарлыг ил тод мэдээлэх замаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийг статусын хувьд ялгарлыг олон нийтэд ойлгуулж цаашид нийтлэл нэвтрүүлгийг Английн ВВС-ийн жишгээр кодтой болгох;

4. *Технологийн хувьд* шинэчлэн бэхжүүлж шуурхай, онцгой нөхцөл байдалд тасралтгүй, хүртээмжтэй байх асуудлыг шийдвэрлэж, иргэд олон нийт Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээр л дамжуулан аюулгүй байдлын мэдээлэл хүлээн авна гэдгээ мэддэг, итгэл төгс байдалд хүргэх;

Цаашид судалгааны ажлыг гүнзгийрүүлэн судлах чиглэл

- Бусад олон улс орнууд болон олон улсын байгууллагуудаас хэвлэл мэдээлэл, аюулгүй байдлын салбарт авч хэрэгжүүлж байгаа зохицуулалтуудыг судалж, Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх;

- Монгол Улсад хэвлэл мэдээллийн болон цахим орчны хэрэглээ аюулгүй байдлын түвшинд хэрхэн нөлөөлж байгаа арга замуудын судалж тодорхойлох;

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийн сэтгэл санааг тогтвортой байлгахад чиглэсэн олон улсын жишгийг судалж, Монгол Улсад нэвтрүүлэх боломжуудыг санал болгох;

- Цахим орчны хүртээмжийг ашиглан Үндэсний аюулгүй байдлыг хангах арга замуудыг судалж, эрх зүйн зохицуулалтыг санал болгох;

ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- [1] Галаарид.Б., Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал //ХСУА. “Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. –УБ., 2016. т.33-38;
- [2] Буянхишиг.С. “Нийгмийн аюулгүй байдлыг хангахад сэтгүүл зүйн бодлогын үзүүлэх нөлөө” докторын зэрэг горилсон диссертаци. УБХИС. УБ 2024.171х
- [3] <https://www.state.gov/russias-pillars-of-disinformation-and-propaganda-report/>
- [4] <https://www.rferl.org/a/russia-ukraine-disinformation-propaganda-campaign/33123498.html>
- [5] <https://www.state.gov/russias-pillars-of-disinformation-and-propaganda-report/>
- [6] <https://www.state.gov/report-rt-and-sputniks-role-in-russias-disinformation-and-propaganda-ecosystem/>
- [7] <https://www.rferl.org/a/russia-ukraine-disinformation-propaganda-campaign/33123498.html>
- [8] Олон нийтийн радио телевизийн тухай хууль, УБ., 2005 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/
- [9] Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, УБ., 2019 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/
- [10] Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992
- [11] Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал, УБ., 2010 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. /Legalinfo.mn/

- [12] 中华人民共和国保守国家秘密法 (1988年9月5日第七届全国人民代表大会常务委员会第三次会议通过, 中华人民共和国主席令第二十八号, 2010年4月29日第十一届全国人民代表大会常务委员会第十四次会议修订) URL: <http://www.mps.gov.cn>.
- [13] https://www.gov.cn/zhengce/zhengceku/202409/content_6977767.htm
- [14] О национальной безопасности: Закон КНР (принят на 15-й сессии Постоянного комитета ВСНП КНР двенадцатого созыва 01.07.2015 г., обнародован Указом Председателя КНР от 01.07.2015 г. № 29) / пер. А.Ю. Манцурова. 中华人民共和国国家安全法 (2015年7月1日第十二届全国人民代表大会常务委员会第十五次会议通过中华人民共和国主席令第二十九号公布) URL: <http://www.mps.gov.cn>.
- [15] <https://www.pewresearch.org/journalism/2021/09/20/news-consumption-across-social-media-in-2021/>
- [17] “Өргөн нэвтрүүлгийн эргэн тойрон дахь асуудлуудад холбогдох судалгааг хэлэлцэх нь”. Гамшгийн үед өргөн нэвтрүүлгийн аюулгүй байдлыг хангах эрдэм шинжилгээний хурлын тайлан. 放送を巡る諸課題に関する検討会 災害時の放送の確保に関する検討分科会 報告書』 https://www.soumu.go.jp/main_content/000700865.pdf
-